

“ОРГАНИК МОНГОЛ” ХӨТӨЛБӨРИЙН ТӨСЛИЙН ЗЭЭЛ ОЛГОХ

Хөтөлбөрийн зорилго: ОРГАНИК МОНГОЛ БРЭНД БҮТЭЭГДЭХҮҮН болж чадахуйц байгаль орчинд ээлтэй **органик ба ногоон бүтээгдэхүүн**, үйлдвэрлэлийг дэмжих, санаачилсан төсөл хөтөлбөрөө бүрэн санхүүжүүлэх боломжгүй аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн боловсруулсан байгаль орчинд хор нөлөөгүй, байгалийн цэвэр бүтээгдэхүүн ашиглан нэмүү өртөг бүхий бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх үр ашигтай бизнес төслийг сонгон хэрэгжүүлэхэд оршино.

Хөтөлбөрийг зохион байгуулагч: “Органик Монгол” Хөтөлбөрийн зохион байгуулах баг болон орон нутгийн Петровис, ХасБанк, Капитал банк, МҮХАҮТ-ын салбарын ажиллагсад,

Хөтөлбөрийн Санхүүжилт:

✓ ХасБанк	200,000,000
✓ Петровис	100,000,000
✓ Капитал банк	100,000,000
✓ Бишрэлт холдинг	100,000,000
✓ Макс групп	20,000,000
Нийт	520,000,000

Хөтөлбөрийн 2014 зорилт:

- ✓ Үндэсний органик брэнд бүтээгдэхүүн болж хөгжих боломжтой, цаашид үйлдвэрлэлээ өргөжүүлэх, зах зээлд таниулах хүсэл эрмэлзэлтэй органик бүтээгдэхүүн үйлдвэрлэгч иргэн, хуулийн этгээдийг дэмжих, олон нийтийн хэрэгслээр сурталчилгаа хийх, борлуулалтын сувгийг бий болгох,
- ✓ Цэвэр байгалийн гаралтай органик бүтээгдэхүүний тариалан эрхэлж, үйлдвэрлэдэг өрхийн бичил бизнес эрхлэгчдийг шаардлагатэй санхүүжилтээр дэмжих, сургалт зөвлөгөө, сурталчилгааг хийх, хамтран ажиллах
- ✓ Хөтөлбөрийн нийт санхүүжилтийг **өрхийн бичил бизнес эрхлэгч** болон **органик брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдэд** тус тус хувиарлах бөгөөд өрхийн бичил бизнесийн зээлийн төслийг Дархан, Сэлэнгэ, Хэнтий, Төв аймагт, брэнд бүтээгдэхүүний үйлдвэрлэгч иргэдийн төслийн шалгаруулалтыг бүх орон нутагт зохион байгуулна.
- ✓ Орон нутгийн өрхийн бичил бизнесийн төслийн шалгаруулалтыг орон нутгийн зохион байгуулагч байгууллагуудын салбарын захирал, эрхлэгчдээс бүрдсэн баг шалгаруулах бөгөөд МҮХАҮТ-ийн байранд шалгаруулалтыг зохион байгуулна.

- ✓ Брэнд бүтээгдэхүүний төслийн зээлийн шалгаруулалтыг орон нутгийн зохион байгуулагч байгууллагуудын салбарын захирал, эрхлэгчдээс бүрдсэн баг эхний ээлжийн шалгаруулалтыг хийж УБ хотын Органик Монгол хөтөлбөрийн зохион байгуулах багт илгээнэ. Ирсэн төслүүд дээр үндэслэн ОМ хөтөлбөрийн зохион байгуулах баг дараагийн шатны шалгаруулалтыг хийх бөгөөд эцсийн шатанд Капитал банк, ХасБанкны бизнесийн боломж болон зээлийн судалгаа хийгдэж зээл олгогдоно.

Хөтөлбөрийн зээлийн сангийн хувиарлалт:

- ✓ Өрхийн бичил бизнесийн зээлийн санд 220 сая
- ✓ Брэнд бүтээгдэхүүний зээлийн санд 300 сая

Өрхийн бичил бизнесийн зээлийн сангаас зээл гаргах аймаг,

- ✓ Дархан уул аймагт
- ✓ Сэлэнгэ аймагт
- ✓ Хэнтий аймагт
- ✓ Төв аймагт
- ✓ Хөвсгөл аймаг,
- ✓ Сүхбаатар,
- ✓ Ховд
- ✓ Өмнөговь

Брэнд бүтээгдэхүүний төслийн зээлийн сангийн хувиарлалт /Аль банкаар судлуулахыг зохион байгуулах баг шийднэ/

- ✓ УБ хотод 100 сая төгрөг,
- ✓ Хөдөө орон нутагт 200 сая төгрөг,

Төслийн зээлийн нөхцөл:

- Зээлийн хэмжээ:**
- Хөдөө Аж Ахуйн гаралтай Органик-Ногоон бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг, тариалдаг иргэд, хуулийн этгээдэд 10,0 хүртэл сая төгрөг
 - Хадгаламж зээлийн хоршоодод 30,0 сая төгрөг хүртэл, */Хадгаламж зээлийн хоршоо нь Капитал банк, ХасБанкны салбар нэгж байхгүй сумдад органик бүтээгдэхүүн үйлдвэрлэж, тариалж байгаа иргэдэд шаардлагатай санхүүжилтийг дамжуулан зээлдүүлэхэд хамтран ажиллана. Дамжуулан зээлдүүлэх төслийн зээлүүд нь өрхийн бичил бизнесийн зээл байх бөгөөд нэг хүнд 5 сая хүртэл төгрөг байна/*
 - Үндэсний органик брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэгч иргэн, хуулийн этгээдэд 30,0 хүртэл сая төгрөг
 - Органик Монгол хөтөлбөрийн хүрээнд бодлогоор дэмжих төслийн зээлийг 70 хүртэл сая төгрөгөөр тусгайлан шийднэ.

- Зээлийн хугацаа:** - Өрхийн органик бичил бизнес эрхлэгч иргэдийн зээл,
ХЗХ-дод 3-12 сар
- Үндэсний органик брэнд бүтээгдэхүүний төслийн зээл
3-36 сар

Зээлийн хүү : - Сарын 1.0 %

Шимтгэл: - Банк тус бүрийн зээлийн журмаар зохицуулагдана.

Зээлийн барьцаа: - Банкны баримталж байгаа бодлого, журмын дагуу,

Хөтөлбөрийн төсөл хүлээн авах, шийдвэрлэх эцсийн хугацаа:

2014 оны 04-р сарын 1-ний өдөр

Брэнд төслийн шалгаруулалт сонголт:

Хөдөө орон нутгаас шалгаруулах үндэсний органик брэнд бүтээгдэхүүний төслийн шалгаруулалтыг хөтөлбөрийн зохион байгуулах баг сонголт хийж хариу өгөх эцсийн хугацаа

2013 оны 04-р сарын 25-ны өдөр

Зээл олголт хийгдэж дуусах хугацаа:

2013 оны 05-р сарын 1-ний өдөр

ОРГАНИК МОНГОЛ ХӨТӨЛБӨРИЙН
ЗОХИОН БАЙГУУЛАХ БАГ
2014 он